

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2026/006/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Говьсүмбэр аймаг
2026 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: baranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Анхтуяа
Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2025.02.10 № 01
танай _____-ны № _____-т

Г ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧ Г.ГАНЦОЛМОН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

4226050031

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,866,938.00</u>	<u>6,323,370.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	6,866,938.00	6,323,370.00
351	Түүхий эд материал	155,000.00	00.00
35130	Эм боох материал	155,000.00	00.00
354	Хангамжийн материал	6,711,938.00	6,323,370.00
35410	Бичиг хэргийн материал	548,000.00	772,670.00
35420	Аж ахуйн материал	2,962,528.00	1,106,600.00
35440	Түлш, шатах тослох материал	500,000.00	555,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,701,410.00	3,889,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>393,571,853.74</u>	<u>421,056,455.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	393,571,853.74	421,056,455.00
392	Биет хөрөнгө	302,776,853.74	330,261,455.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	246,539,963.90	246,402,283.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	(35,124,167.52)	(40,640,515.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,450,000.00	72,643,750.12
39204	Хуримтлагдсан элэгдэл	(20,000,000.00)	(25,566,666.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	96,831,694.94	107,458,494.94
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,580,999.78)	(32,512,135.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,715,838.00	6,765,838.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,055,475.80)	(4,289,594.40)
393	Биет бус хөрөнгө	90,795,000.00	90,795,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	90,795,000.00	90,795,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>400,438,791.74</u>	<u>427,379,825.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,873,527.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,873,527.00	00.00
413	Өглөг	1,873,527.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,873,527.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>398,565,264.74</u>	<u>427,379,825.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	398,565,264.74	427,379,825.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	252,293,654.92	252,293,654.92
51101	Өмч: - төрийн	252,293,654.92	252,293,654.92
512	Хуримтлагдсан үр дүн	67,618,188.50	96,432,748.76
51210	Өмнөх үеийн үр дүн	67,618,188.50	67,618,188.50
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	28,814,560.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	78,653,421.32	78,653,421.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>400,438,791.74</u>	<u>427,379,825.00</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	396,866,040.00	519,491,350.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,610,940.00	44,217,750.12
120	Нийтлэг татварын бус орлого	30,610,940.00	44,217,750.12
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	366,255,100.00	475,273,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	366,255,100.00	475,273,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	366,255,100.00	475,273,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	378,530,323.51	490,676,789.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	378,530,323.51	490,676,789.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	324,222,921.48	428,521,911.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	243,211,805.78	313,258,483.17
210101	Үндсэн цалин	125,857,673.78	163,811,696.50
210102	Нэмэгдэл	76,643,545.00	98,702,523.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,553,525.00	31,453,862.94
210104	Урамшуулал	21,157,062.00	19,290,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,507,123.68	9,051,817.72
210201	Тэтгэврийн даатгал	604,843.00	2,253,726.22
210202	Тэтгэмжийн даатгал	71,158.00	180,664.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,579.00	90,332.14
210204	Ажилгүйдлийн даатгал	35,579.00	90,332.14
210205	Эрүүл мэндийн даатгал	4,759,964.68	6,436,762.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,178,192.53	17,074,345.46
210301	Гэрэл, цахилгаан	714,552.53	1,084,685.46
210302	Түлш, халаалт	15,394,360.00	15,393,840.00
210303	Цэвэр, бохир ус	69,280.00	595,820.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,233,390.00	19,278,193.00
210401	Бичиг хэрэг	4,065,000.00	3,483,830.00
210402	Тээвэр, шатахуун	3,874,370.00	7,607,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	795,820.00	715,625.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	210,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	470,500.00	4,774,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	817,700.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	2,577,238.00
2105	Нормативт зардал	5,852,200.00	9,246,598.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,822,750.00	7,880,098.00
210502	Хоол, хүнс	2,029,450.00	1,366,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,155,880.00	13,011,520.00
210604	Урсгал засвар	13,155,880.00	13,011,520.00
2107	Томилолт, зочны зардал	3,140,000.00	4,560,000.00
210702	Дотоод албан томилолт	3,140,000.00	4,560,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,704,786.00	9,815,405.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	137,840.00	8,793,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,192,356.00	713,610.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,000.00	152,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	181,590.00	90,795.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,239,543.49	33,225,548.86
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,239,543.49	33,225,548.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,307,402.03	62,154,878.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,270,098.80	31,358,605.77
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,658,098.80	31,358,605.77
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	612,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,037,303.23	30,796,272.88
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,037,303.23	30,796,272.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>18,335,716.49</u>	<u>28,814,560.26</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>18,335,716.49</u>	<u>28,814,560.26</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>367,552,700.00</u>	<u>475,273,600.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,297,600.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,297,600.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,297,600.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,297,600.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	366,255,100.00	475,273,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	366,255,100.00	475,273,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	366,255,100.00	475,273,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>349,552,700.00</u>	<u>456,806,200.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>349,552,700.00</u>	<u>456,806,200.00</u>

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	295,245,297.97	394,651,321.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	237,538,278.78	315,132,010.17
210101	Үндсэн цалин	122,268,646.78	168,067,814.85
210102	Нэмэгдэл	76,432,572.00	97,007,266.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,679,998.00	30,766,529.01
210104	Урамшуулал	21,157,062.00	19,290,399.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,461,170.66	8,164,777.72
210201	Тэтгэврийн даатгал	1,050,463.88	1,554,312.81
210202	Тэтгэмжийн даатгал	71,158.00	180,236.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,579.00	90,332.14
210204	Ажилгүйдлийн даатгал	35,579.00	72,093.27
210205	Эрүүл мэндийн даатгал	4,268,390.78	6,267,802.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,178,192.53	17,074,345.46
210301	Гэрэл, цахилгаан	714,552.53	1,084,685.46
210302	Түлш, халаалт	15,394,360.00	15,393,840.00
210303	Цэвэр, бохир ус	69,280.00	595,820.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,853,390.00	15,567,025.00
210401	Бичиг хэрэг	4,655,000.00	2,901,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,164,370.00	7,662,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	795,820.00	715,625.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	210,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,028,200.00	4,167,500.00
2105	Нормативт зардал	6,372,200.00	9,217,598.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,342,750.00	7,725,098.00
210502	Хоол, хүнс	2,029,450.00	1,366,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	126,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,997,280.00	13,983,120.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	971,600.00
210604	Урсгал засвар	13,997,280.00	13,011,520.00
2107	Томилолт, зочны зардал	3,140,000.00	4,560,000.00
210702	Дотоод албан томилолт	3,140,000.00	4,560,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,704,786.00	10,952,445.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	137,840.00	9,680,040.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,192,356.00	713,610.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,000.00	152,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	181,590.00	90,795.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,307,402.03	62,154,878.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,270,098.80	31,358,605.77
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,658,098.80	31,358,605.77
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	612,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,037,303.23	30,796,272.88

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,037,303.23	30,796,272.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>18,000,000.00</u>	<u>18,467,400.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	18,000,000.00	18,467,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,000,000.00	18,467,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,000,000.00	18,467,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,000,000.00	18,467,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(18,000,000.00)</u>	<u>(18,467,400.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,293,654.92	78,653,421.32	45,966,997.47	00.00	376,914,073.71
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	252,293,654.92	78,653,421.32	45,966,997.47	00.00	376,914,073.71
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,017,874.54	00.00	2,017,874.54
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,293,654.92	78,653,421.32	67,618,188.50	00.00	398,565,264.74
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,293,654.92	78,653,421.32	67,618,188.50	00.00	398,565,264.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	252,293,654.92	78,653,421.32	67,618,188.50	00.00	398,565,264.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	28,814,560.26	00.00	28,814,560.26
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,293,654.92	78,653,421.32	96,432,748.76	00.00	427,379,825.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	488,186,800.00	444,477,327.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	488,186,800.00	444,477,327.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,470,800.00	413,118,721.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,991,000.00	315,132,010.17
210101	Үндсэн цалин	169,058,400.00	168,067,814.85
210102	Нэмэгдэл	104,259,100.00	97,007,266.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,466,500.00	30,766,529.01
210104	Урамшуулал	38,207,000.00	19,290,399.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,747,300.00	8,164,777.72
210201	Тэтгэврийн даатгал	5,660,000.00	1,554,312.81
210202	Тэтгэмжийн даатгал	309,100.00	180,236.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	247,300.00	90,332.14
210204	Ажилгүйдлийн даатгал	111,400.00	72,093.27
210205	Эрүүл мэндийн даатгал	7,419,500.00	6,267,802.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,274,400.00	17,074,345.46
210301	Гэрэл, цахилгаан	1,282,400.00	1,084,685.46
210302	Түлш, халаалт	15,393,900.00	15,393,840.00
210303	Цэвэр, бохир ус	598,100.00	595,820.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,274,700.00	15,567,025.00
210401	Бичиг хэрэг	4,638,300.00	2,901,900.00
210402	Тээвэр, шатахуун	7,980,200.00	7,662,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	780,100.00	715,625.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	239,900.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,636,200.00	4,167,500.00
2105	Нормативт зардал	12,074,300.00	9,217,598.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,783,600.00	7,725,098.00
210502	Хоол, хүнс	2,014,700.00	1,366,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	276,000.00	126,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,098,800.00	32,450,520.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,439,000.00	19,439,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	181,700.00	00.00
210604	Урсгал засвар	13,478,100.00	13,011,520.00
2107	Томилолт, зочны зардал	5,400,000.00	4,560,000.00
210702	Дотоод албан томилолт	5,400,000.00	4,560,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,610,300.00	10,952,445.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,933,500.00	9,680,040.00
210803	Даатгалын үйлчилгээ	989,600.00	713,610.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	166,400.00	152,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	89,600.00	66,000.00
210807	Газрын төлбөр	181,200.00	90,795.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	250,000.00	250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,716,000.00	31,358,605.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,716,000.00	31,358,605.77
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,359,000.00	31,358,605.77
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	357,000.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	488,186,800.00	444,477,327.12
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	488,186,800.00	444,477,327.12
131001	Улсын төсвөөс санхүүжих	488,186,800.00	444,477,327.12
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	10.00	10.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	09.00

3. Аудитын илрүүлэлт:

Завсрын аудитаар:

Тус байгууллагад 2025 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд завсрын аудит гүйцэтгэж, нийт 7 горим сорилыг хэрэгжүүлж, асуудлын бүртгэлээр 971.6 мянган төгрөгийн 1 алдааг залруулах зөвлөмж өгсөн байна. Нийт 971.6 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

3.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.2.1 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

3.2.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчил илрээгүй байна.

4. Аудитаар нийт 969.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 969.4 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулсан алдаа:

1. Ерөнхий журналд 969.4 мянган төгрөгийн цалингийн зардлыг бууруулах бичилт хийж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын Гуравдугаар бүлэг: Зардал дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй.

Залруулаагүй алдаа:

Байхгүй

Аудитаар нийт 2,228.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,228.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгсөн.

4.1 Төлбөрийн акт

Байхгүй

4.2 Албан шаардлага

4.2.1 Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 4 хөрөнгийг одоогийн зах зээлийн үнэ ханштай харьцуулахад процессор, дэлгэц 2 хөрөнгийг нийт 2,228.8 мянган төгрөгөөр илүү өндөр үнээр худалдан авсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “үр ашигтай байх” “УСНББОУС 1.27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой” заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн худалдан авалтыг харьцуулалт хийж, зах зээлийн үнэ, ханштай дүйцүүлэн худалдан авалтыг зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй

Тав. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шүүхийн шинжилгээний хэлтэс	2	1.9			2	1.9	2	1.9				
Дүн	2	1.9			2	1.9	2	1.9				

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шүүхийн шинжилгээний хэлтэс	1	2.2			1	2.2						
Дүн	1	2.2			1	2.2						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шүүхийн шинжилгээний хэлтэс										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Шүүхийн шинжилгээний хэлтэс										
Дүн										
Нийт дүн										

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			